

# СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ХЭЛТЭС

## ДЭЛГЭРГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн  
2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тухай

### **Байгууллагын чиг үүргийн хүрээнд:**


Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсээс албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн edoc.ulaanbaatar.mn программыг бүрэн ашиглаж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 04-ний хооронд нийт 30 албан бичиг ирснээс хариутай 20 бичиг ирж, хугацаанд нь шийдвэрлэж шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Явуулсан албан тоот 45, үүнээс хариутай албан бичиг 104 байгууллага, аж, ахуйн нэгжид илгээсэн байна.

### **БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ**

Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсээс 2024 оны жилийн эцсийн байдлаар биеийн тамирын 18 арга хэмжээ зохион байгуулж 1995 байгууллагын 450200 иргэдийг хамруулж улсын төсвөөс 52,698,000 төгрөг, Засаг даргын нөөц сангаас 1,018,204,050 төгрөг, нийт 1,070,902,020 төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэл, дүүргийн хэмжээнд 345 удаагийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж, 8909 байгууллагын 888500 иргэдийг хамруулж Улсын төсвөөс 701,487,030 төгрөг, Засаг даргын нөөц сангаас 1,584,309,430 төгрөг, бусад төсөв 36,993,000 төгрөг, нийт 2,322,789,460 төгрөгийг зарцуулсан байна.



### **БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГ**

Нийслэлийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 816 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг шалгаруулах болзлын дагуу 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Нийслэлийн хүнс хөдөө, аж ахуйн газар, СХД-ийн 113-р цэцэрлэг, БЗД-ийн 62-р цэцэрлэг, ЧД-ийн 74-р цэцэрлэгийн хамтлагуудыг “Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг”-аар шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.




### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БИЕЙН ТАМИРЫН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш нарт зориулсан сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 29-31-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны V байрны “Иргэний танхим”, Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт тус тус зохион байгуулж 9 дүүргийн 320 цэцэрлэгийн 530 биеийн тамирын багш нар хамрагдсан.



### НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БИЕЙН ТАМИРЫН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ОНОЛ, ПРАКТИКИЙН СУРГАЛТ

Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нарт зориулсан онол практикийн сургалтыг Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран 2024 оны 01 дүгээр сарын 31-нээс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны V байрны “Иргэний танхим”, Ган спорт цогцолборт тус тус зохион байгуулж 9 дүүргийн 100 сургуулийн 200 биеийн тамирын багш нар хамрагдлаа.



### АЭРОБИКИЙН ДАСГАЛ СУРГАГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ

Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Аэробикийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 29-31-ний өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран Ган спорт цогцолборт зохион байгуулж 9 дүүргийн 80 хороо 230 биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, арга зүйчид хамрагдлаа.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/59 дүгээр захирамжаар Нийслэлийн өвлийн спортын наадмыг 9 төрлөөр зохион байгуулахаар 70,486,000 төгрөгийн санхүүжилтийн аваад байна.

Энэ хүрээнд 2024 оны 01 дүгээр сард өвлийн спортын 4 төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 328 тамирчид оролцсон.

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН “АЛХАЦГААЯ ГҮЙЦГЭЭ” ХӨДӨЛГӨӨН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хөнгөн атлетикийн суурьтай дасгал хөдөлгөөнөөр иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх зорилгоор “Алхацгаая гүйцгээ” хөдөлгөөнийг нийслэлийн хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 15–наас 10 дугаар сарын 01-ний хүртэлх хугацаанд өрнүүлж, сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Бямба гаригт иргэд нийтийн алхалт, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх ажлыг зохион байгуулсан.

Удирдамжийн хүрээнд Нийслэлийн 9 дүүргүүд ажлын байрны дасгал, шугаман бүжиг, аэробик, хийн дасгал, алхалт, гүйлтийн арга хэмжээг иргэдийн дунд 54 арга

хэмжээг зохион байгуулж жилийн эцсээр нийт давхардсан тоогоор 416 байгууллагын 231890 иргэнийг хамруулсан.

### НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ХӨГЖӨӨН ДЭМЖИГЧДИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Хөгжөөн дэмжигчдийн анхдугаар тэмцээнийг Монголын Спорт сонирхогч хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран 2024 оны 04 дүгээр сарын 14-23-ны хооронд 3 насны ангиллаар, 2 үе шаттай амжилттай зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 48 сургуулийн 188 багийн 2938 сурагч оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Монгол бөхийн өргөөнд зохион байгуулж, 7 дүүргийн 33 сургуулийн 56 багийн 896 сурагч ур чадвар, авьяасаа сорин өрсөлдсөн.



### УЛААНБААТАР ХОТЫН 2024 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН


Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2 үе шаттай 2024 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд дүүрэг, нийслэл гэсэн 2 үе шаттай зохион байгуулж, Нийслэлийн 9 дүүргийн 79 цэцэрлэгийн 2439 хүүхэд оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулж, 9 дүүргийн 20 цэцэрлэгийн 600 хүүхэд багачууд ур чадвар, авьяасаа сорин өрсөлдлөө.



## ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 483 байгууллагыг 193,000 иргэн хамрагдсан бол сорилд хамрагдсан нийт иргэдийн 82 хувь нь А, В, С үнэлгээ авсан үзүүлэлттэй үнэлэгдсэн байна.



### “УЛААНБААТАР МАРАФОН-2024” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийг өдөр тутмын биеийн тамираар хичээллэх идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/241, А/453 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафон 2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулсан.



“Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтэд оролцогчдыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс [ubmarathon.hiraу.mn](http://ubmarathon.hiraу.mn) цахим хуудас, “Hiraу” аппликэйшнээр онлайн бүртгэл болон Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байр, 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын байр, Хай пэймэнт солюшнс” ХХК-ны байр, нэмэлтээр Д.Сүхбаатарын талбай, Улсын их дэлгүүрийн урд байрлах фантан нийт 13 бүртгэлийн штаб ажиллаж иргэдийн сонирхлын дагуу шууд бүртгүүлэх ба онлайн бүртгэлд мэдээлэл оруулах, энгэрийн дугаар, подволк, уут, чип тусгай төхөөрөмжинд уншуулж баталгаажуулах ажлыг тус тус зохион байгуулсан.



“Улаанбаатар Марафон 2024” олон улсын гүйлтийг 42 км 18-аас дээш нас, ХБИ, гар дугуйн уралдаан, 21 км-ийн зайг 18-34, 35-54, 55-аас дээш нас, ХБИ, 5 км-ийн зайг 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,5 км (хараагүйны бэрхшээлтэй, тэргэнцэртэй гэр бүл) 400м, 800м-ийн зайг тусгай олимпын тамирчид гэсэн ангиллаар тус тус зохион байгуулж нийт 22657 иргэд цахимаар, 7350 иргэн биеэр ирж бүртгүүлэн нийт 30000 иргэн оролцсон.

#### “ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-Т ЗОРИУЛСАН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/604 захирамжийн дагуу “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулсан тэнцвэрт дугуй, дугуй, шатар, даам, хип поп бүжиг, ширээний шагайн тэмцээнийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр 08:00-17:00 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын арга хэмжээг Монголын дугуйн холбоо, Монголын спорт сонирхогч хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын ширээний шагайн холбоо, Нийслэлийн даамны холбоо, Зууны шатрын клуб, Монголын хип поп чөлөөт бүжгийн холбоодтой хамран зохион байгуулж нийт 480 гаруй хүүхэд оролцсон.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/604 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр 11,745,000 (арван нэгэн сая долоон зуун дөчин таван мянган) төгрөгийг санхүүжүүлэх гэрээг хэрэгжилтийг ханган ажилласан.



#### “ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ” ШАШИН СОЁЛЫН НААДМЫН БӨХИЙН БАРИЛДААН, ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/850 дугаар захирамжаар 2024 оны 08 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Хүй долоо худагт зохион байгуулагдсан “Даншиг наадам хүрээ

цам” шашин соёлын наадмын бөхийн барилдааныг Монголын Үндэсний бөхийн холбоо, Үндэсний сурын харвааг Монголын Үндэсний сурын харваатай хамтран зохион байгуулсан. Бөхийн барилдаанд хүрээнд Өвөрмонгол 64 бөх, Буриад 64 бөх, Үндэсний 246 бөх оролцож бяра хүчээ сорин өрсөлдсөн.



Үндэсний сурын харваанд 21 аймгийн 200 гаруй харваачид оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдсөн.



5-р байрыг Өмнөговь аймгийн Номгон сумын уугуул хилийн цэргийн 0208-р тусгай салбар хилчин спорт хороо, Есүньхэй мэргэн клубийн тамирчин монгол улсын онч харваач Батхуягийн Сүрэнжаргал 33 оноогоор

4-р байрыг Дорнод аймгийн Дашбалбар сумын уугуул номин холдинг ххк, номин үндэсний сурын клубийн харваач аймгийн гоц харваач спортын мастер Эрдэнэбаатарын Дуламжав 33 оноогоор

3-р байрыг Дорнод аймгийн Дашбалбар сумын уугуул номин холдинг ххк, номин үндэсний сурын клубийн харваач монгол улсын мэргэн Батын Бутваан спортын мастер 33 оноогоор

2-р байрыг Өвөрхангай айгийн хужирт сумын уугуул номин холдинг ххк, номин үндэсний сурын клубийн харваач аймгийн гоц харваач Ганпүрэвийн Энхзул 36 оноогоор

Тэргүүн байрыг Баян-өлгий аймгийн Буянт сумын уугуул Эрхэт гурван түрүү үндэсний сурын холбооны харваач спортын мастер Өвгөнхүүгийн Энхнамуун 36 оноогоор



5-р байрыг Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын уугуул Хөвсгөл аймгийн харваачдын холбоо Ган зэв клубийн харваач аймгийн гарамгай харваач спортын мастер Балжиннямын Лутсайхан 33 оноогоор

4-р байрыг Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын уугуул Дундговь аймаг их мандал зурхай, мандал говь хүнс ххк, цахиур багийн харваач аймгийн гарамгай харваач спортын мастер Ганболдын Мөнхсайхан 34 оноогоор

3-р байрыг Завхан аймгийн Алдархаан сумын уугуул Завхан аймгийн харваачдын холбоо, хаан даатгал ххк, тэнгэр энд тэнгис ххк-н харваач спортын дэд мастер Батмөнхийн Батсайхан 35 оноогоор

2-р байрыг Дорноговь аймгийн Улаанбадрах сумын уугуул ийст говь ххк, Сайншанд сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн багш, өнөд цэнгэлийн манлай харваачдын холбооны харваач аймгийн тод харваач спортын мастер Эрдэнэжаргалын Уранжаргал 35 оноогоор

Тэргүүн байрыг Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Архангай аймгийн үндэсний сурын холбоо, говь эрдэнэ кашмер ххк, ханagar хангай клубийн харваач аймгийн мэргэн спортын дэд мастер Батчулууны Түвшинбаяр 35 оноогоор тус тус шалгарсан.

### НҮҮДЭЛЧИН ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦЛОО

Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/511 дүгээр тушаалаар “НҮҮДЭЛЧИН ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ” үндэсний спортын арга хэмжээнд Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, Үндэсний спорт сурталчлах зорилгоор Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын албан хаагчид 2024 оны 08 дугаар сарын 16-18-ний өдрүүдэд Налайх дүүрэг “Тайж хайрхан бэл”-д ажилласан.

Энэ хүрээнд нүүдэлчин соёлыг харуулах 8 ханатай үндэсний хээг харуулсан гэр барьж, эрийн гурван наадам болох үндэсний бөхийн барилдаан, үндэсний сурын харваа, морин уралдаан, шагайн харваа, шагайн наадгай, үндэсний уламжлалт уран зургууд, нум сум, бүрэн тоноглолтой эмээл, хурдан морины хэрэгслээр тохижуулж гадаад болон дотоодын 2000 гаруй иргэдэд үйлчилсэн танилцуулсан.





Нүүдэлчин уламжлалыг олонд түгээж айраг, тавгийн идээ болон морин хуур, хөөмий, үндэсний спортыг сурталчилсан ерөөлч нар урлагийн тоглолт үзүүлэн, шагайн харваа, шагай атгах, шагай шүүрэх, морь уралдуулах гэх мэт үндэсний тоглоом наадгай тоглуулж олон түмэнд үйлчилсэн.



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XII НААДАМ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1363 дугаар захирамжаар Нийслэлийн Иргэдийн спортын XII наадмыг 2024 оны 07 дугаар сараас 11 дүгээр сарын 27-ны хооронд спорт явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр 5 үе шат (хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл)-тайгаар амжилттай зохион байгуулсан.

Нийслэлийн Иргэдийн спортын XII наадамд нийт 9 дүүргийн 204 хорооны 90100 иргэн оролцсон.



Энэхүү наадам нь багийн бүрэлдэхүүнд 31-ээс дээш настай нийслэлийн иргэн байх, тухайн төрлийн спортын дэд мастераас дээш цолтой тамирчин 45-аас дээш настай байх, наадмын нэг төрөлд нэг тамирчин орох, шалгарсан баг тамирчид үндсэн бүрэлдэхүүнээрээ шат шатны тэмцээнд оролцох зэрэг нь бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, хүн амыг биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, хөршийн холбоог сайжруулах зэрэг онцлог шинжтэй үйл ажиллагаа болсон.

#### УЛААНБААТАР ХОТЫН 2024 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 1976 оноос 46 дахь жилдээ 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр шигшээ тэмцээнийг Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран зохион байгуулсан.



Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн нь 2 үе шаттай зохион байгуулагдаж, анхан шатны тэмцээнд Нийслэлийн 9 дүүргийн 38 сургуулийн 1850 сурагч оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр спортын төв ордны А зааланд зохион байгуулж 7 дүүргийн 30 сургуулийн 796 сурагчид ур чадвар, авьяасаа сорин өрсөлдсөнөөс:



### СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 23 удаа зохион байгуулж, 301 байгууллагын 7888 тамирчдыг оролцуулж нийт 66,175,000 төгрөгийг зарцуулсан.

Нийслэл дүүргийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар спортын уралдаан тэмцээнийг 219 удаа зохион байгуулж 12311 байгууллагын 213896 тамирчдыг оролцуулж нийт 693,861,700 төгрөгийг зарцуулсан.

### ӨВЛИЙН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 414,200 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Үүнд:

Нийслэлийн 9 дүүрэгт өвлийн спортын нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 25,909 иргэнийг хамруулсан.

Монголын Тэшүүр, Хоккейн холбооны дэргэдэх бүртгэлтэй дугуйлан, секцэд 175 хүүхэд спортын 3 (тэшүүр, хоккей, уран гулгалт) төрөлд хамрагдаж байна. Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 05-ны хооронд 129,054 иргэн үйлчлүүлсэн байна.

Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэг дэх Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153,000 иргэн үйлчлүүлсэн.

Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 105,544 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон.

Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорт-трейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна.

### НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ МӨСӨН ШАГАЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах мөсөн шагайн тэмцээнийг 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Монголын үндэсний мөсний шагайн холбоотой хамтран зохион байгуулж 9 дүүргийн 90 гаруй тамирчид оролцлоо.



### НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СНӨУБОАРДЫН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах снөүбоардын тэмцээнийг 2024 оны 01 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Монголын мэргэжлийн снөүбоардын холбоотой хамтран зохион байгуулж 63 тамирчид оролцсон.



### НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ВИРТУАЛ ДУГУЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Виртуал дугуйн тэмцээнийг 2024 оны 02 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Монголын дугуйн холбоотой хамтран зохион байгуулж 6 насны ангиллаар 85 тамирчид оролцсон.



### НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭШҮҮРИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээнийг 2024 оны 02 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Монголын тэшүүрийн холбоотой хамтран зохион байгуулж 90 тамирчид оролцсон.



### НИЙСЛЭЛИЙН ӨВЛИЙН СПОРТЫН НААДМЫН УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ МӨСӨН СУРЫН ХАРВААНЫ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Өвлийн спортын наадмын Улаанбаатар хотын аварга шалгаруулах Тэшүүрийн тэмцээнийг 2024 оны 02 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Монголын мөсөн сурын холбоотой хамтран зохион байгуулж 15 байгууллагын 150 тамирчин оролцсон.



## УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЗУУН БУУДАЛТ ДААМНЫ ТЭМЦЭЭН

Цаглашгүй Монгол ухаан ТББ хамтран Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах өсвөр үеийн зуун буудалт даамны тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулж 9 байгууллагын 240 тамирчид оролцож, улсын төсвөөс 2,200,000 төгрөгийг зарцуулсан.



## УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭН

Монголын Ширээний теннисний холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд Ширээний теннисний Оч клубт зохион байгуулж 15 байгууллагын 350 тамирчид оролцож, улсын төсвөөс 3,360,000 төгрөгийг зарцуулсан байна.




## УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ӨСВӨР ҮЕИЙН ЖУДО БӨХИЙН ТЭМЦЭЭН



Монголын Жүдо бөхийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Жүдо бөхийн тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж 42 байгууллагын 1724 тамирчид оролцож, улсын төсвөөс 5,760,000 төгрөг зарцуулсан.

### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ БАЙТ ХАРВААНЫ ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Байт харвааны тэмцээнийг 2024 оны 08 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Монголын Байт харвааны холбоотой хамтран зохион байгуулж 12 байгууллагын 89 тамирчид 16 багц медалийн төлөө цэц мэргэнээ сорин өрсөлдсөн.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ПАРА БАДМИНТОН ТЭМЦЭЭН

Монголын Паралимпын бадминтоны холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Налайх дүүргийн Хүүхэд гэр бүл хөгжил, хамгааллын хэлтсийн спорт зааланд зохион байгуулсан.

Тэмцээнд гарын бэрхшээлтэй, хөлийн бэрхшээлтэй, гарын SU4-5, хөлийн SL3-4 холимог хос, тэргэнцэртэй буюу WH1-2 гэсэн 4 төрлөөр зохион байгуулж 4 байгууллагын 30 гаруй тамирчид оролцсон.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ПАРА БОЧИГИЙН ТЭМЦЭЭН

Монголын парабочигийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах парабочигийн тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 63 дүгээр сургуулийн спорт зааланд зохион байгуулсан.

Тэмцээнд 10 байгууллагын 40 тамирчдад оролцсон.



### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/200 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, ОХУ-ын Школьная баскетбольная лига “КЭС-БАСКЕТ” Төрийн бус байгууллага хамтран 2023 оны 12 дугаар сарын 01-нээс 2024 оны 03 дугаар сарын 22-ны хооронд 3 насны ангиллаар, 5 үе шаттай амжилттай зохион байгуулсан.

Бага, дунд, ахлах насны ангиллаар нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 192 сургуулийн охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 мянга гаруй сурагч оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд нийслэлийн шатанд бага, дунд, ахлах насны шилдэг нийт 52 сургуулийн 96 багийн 1152 тамирчид өрсөлдсөн.





Нийслэлийн шатанд шалгарсан эрэгтэй, эмэгтэй 96 багийн урьдчилсан тоглолтын оноолт - сугалааг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Нийслэлийн нутгийн захиргааны "Хангарди" ордны 14 давхрын "А" танхимд зохион байгуулж, дүүрэг бүрээс шалгарсан шилдэг багуудын багш-дасгалжуулагч нарт "Батламж" гардуулсан.

<p>2:28</p>	<p>0:41</p>	<p>7:39</p>
<p><b>ЕБС-ийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн шигшээ...</b> нэг өдрийн өмнө · 5.3М удаа үзсэн 👍❤️ 189</p>	<p><b>ЕБС-ийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн шигшээ...</b> нэг өдрийн өмнө · 10.2М удаа үзсэн 👍❤️👍 220</p>	<p><b>Таны бичлэг</b> 3 өдрийн өмнө · 758 удаа үзсэн 👍 11</p>
<p>1:32</p>	<p>30:36</p>	<p>32:30</p>
<p><b>ХУД-БНД</b> 3 өдрийн өмнө · 667 удаа үзсэн 👍❤️ 10</p>	<p><b>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар..."</b> 3 өдрийн өмнө · 1.4М удаа үзсэн 👍❤️👍 22</p>	<p><b>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар..."</b> 3 өдрийн өмнө · 1.4М удаа үзсэн 👍❤️👍 34</p>
<p>7:29</p>	<p>15:10</p>	<p>15:14</p>
<p><b>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар..."</b> 3 өдрийн өмнө · 2.1М удаа үзсэн 👍❤️👍 23</p>	<p><b>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар..."</b> 3 өдрийн өмнө · 1М удаа үзсэн 👍❤️👍 22</p>	<p><b>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар..."</b> 3 өдрийн өмнө · 1.5М удаа үзсэн 👍❤️👍 21</p>

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ”  
ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН**

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2023 оны 12 дугаар сарын 01-нээс 2024 оны 04 дүгээр сарын 29-ний хооронд 2 насны ангиллаар, 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн охид, хөвгүүдийн 520 багийн 67098 мянга сурагч оролцсон бол нийслэлийн шигшээ тэмцээнийг 2024 оны 04 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд нийслэлийн шатанд дунд, ахлах насны шилдэг нийт 41 сургуулийн 64 багийн 832 тамирчид өрсөлдсөн.

Нийслэлийн шатанд шалгарсан эрэгтэй, эмэгтэй 64 багийн урьдчилсан тоглолтын оноолт - сугалааг 2024 оны 04 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны “Хангарди” ордны 14 давхрын “А” танхимд зохион байгуулж, дүүрэг бүрээс шалгарсан шилдэг багуудын багш-дасгалжуулагч нарт “Батламж” гардуулсан.



**УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН**

Монголын Гимнастикийн холбоотой хамтран Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах өсвөр үеийн Уран сайхны гимнастикийн тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Спортын төв ордонд зохион байгуулж 11 байгууллагын 315 тамирчид оролцож улсын төсвөөс 1,800,000(нэг сая найман зуун мянган) төгрөгийг зарцуулсан.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТ АВИРАЛТЫН ТЭМЦЭЭН

Монголын Уулчдын холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Спорт авиралтын тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Хурд спортын авиралтын зааланд зохион байгуулж 12 байгууллагын 60 тамирчид оролцож улсын төсвөөс 1,600,000(нэг сая зургаан зуун мянган) төгрөгийг зарцуулсан.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН

Монголын Гимнастикийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Спортын гимнастикийн тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Монголын гимнастикийн холбооны спорт цогцолборт зохион байгуулж 8 байгууллагын 155 тамирчид оролцож улсын төсвөөс 1,200,000(нэг сая хоёр зуун мянган) төгрөгийг зарцуулсан.



### “МӨРӨӨДЛИЙН ГООЛ” ХӨЛ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/483 дугаар захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Мөрөөдлийн гоол” хөл бөмбөгийн нийслэлийн бүсийн тэмцээнийг Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран 2024 оны 05 дугаар сарын 06-17-ны өдрүүдэд МХБХ-ны Шинэ яармаг дахь цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж 6 насны ангилалд 66 багийн 1000 гаруй тамирчид оролцсон.



### “УЛААНБААТАР ЦОМ” ХӨЛ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/483 дугаар захирамжаар нийслэлийн иргэдийн дунд “Улаанбаатар цом” хөл бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд МХБХ-ны футзаалын ордонд Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 7 дүүргийн 98 тамирчин оролцсон.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХОНХОТ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Хонхот бөмбөгийн холбоотой хамтран Улаанбаатар хотын 2024 оны аварга шалгаруулах Хонхот бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж 9 байгууллагын 45 тамирчид оролцож, улсын төсвөөс 2,600,000 төгрөгийг зарцуулсан.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ҮНДЭСНИЙ СУРЫН ТЭМЦЭЭН

Монголын Үндэсний Сурын харвааны холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Үндэсний сурын тэмцээнийг 2024 оны 05 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Хүй долоон хутагт Монгол наадам цогцолборт зохион байгуулж 12 байгууллагын 150 тамирчид оролцож, улсын төсвөөс 2,400,000 төгрөгийг зарцуулсан.



### УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СОФТ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭН

Монголын Софт теннисний холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Софт теннисний тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд Софт теннисний талбайд зохион байгуулж 9 байгууллагын 120 тамирчид оролцож, улсын төсвөөс 2,640,000 төгрөгийг зарцуулсан.



### ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН

Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулсан.

Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 оны жилийн эцсийн байдлаар тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 521 удаагийн тэмцээнд оролцож 2707 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 288,230,241(хоёр зуун наян найман сая хоёр зуун гучин мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөгийг зарцуулсан байна.

НЭГТГЭСЭН:  
СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХ-ЭРДЭНЭ